



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 14/05

Баянбулаг

**Сумын сайн малчны журамд
өөрчлөлт оруулах тухай**

Монголд Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13, 35.1.17 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн А/689 дугаар захирамжийг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын ээлжит XIV хуралдаанаас ТОГТООХ нь.

1. Сумын сайн малчин шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг малчид, ард иргэдэд хүргэж сурталчилан таниулах ажлыг Мал эмнэлгийн тасаг, Хөдөө аж ахуйн тасаг, багуудын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Н.НАМГАРРЕНЧИН



648803083

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны
03 дугаар сарын 31 өдрийн ээлжит 14 дүгээр
хуралдааны 14 тогтоолын хавсралт

СУМЫН САЙН МАЛЧИН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

1. Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгох, малын ашиг шимийн гарц, чанарыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өсгөх болон нийгэмд оруулж байгаа малчдын хувь нэмрийг үнэлж урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.

Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан 8 хүртэлх малчныг 2 жилийн ажлын үзүүлэлтээр “Сумын сайн малчин”-аар жил бүр шалгаруулах.

2. Үндсэн шалгуур

2.1. Байгальд ээлтэй, өрхийн орлого тогтвортой, эрсдэлгүй нөхцөлд мал аж ахуйн үйлдвэрлэлээ эрхлэх нь сумын сайн малчны үндсэн шалгуур үзүүлэлт байна.

2.2. Хээлтэгч малаа бүрэн төллүүлж төлөө бүрэн бойжуулж тухайн жилд бойжуулсан төлийн тоо толгойноос багагүй тоогоор зах зээлд борлуулсан байх, нас гүйцсэн 4-с дээш насны эрэг, сэрх хижээл насны хээлтэгч малыг зах, зээлд бүрэн борлуулсан байж сүргийн эргэлтийн зохистой харьцааг хангасан байна.

3. Сумын Сайн малчин дараах үзүүлэлтийг хангасан байх

3.1. Мал сүргээ малын индексжүүлсэн даатгалд хамруулан холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар, хураамжийг тогтмол төлсөн байх.

3.2. Мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл эрхлэх өрхийн орлогыг нэмэгдүүлэх,

3.3. Мал сүргээ эрүүлжүүлэх, халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан эрүүл сүрэгтэй болсон байх.

3.4. Малчин өрхийн хүн бүр эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд бүрэн хамрагдаж шимтгэлийг нь тогтмол төлсөн байх.

3.5. Бодод шилжүүлснээр 60-с доошгүй толгой малтай, малын зүй бусын хорогдолгүй байх.

3.6. Хээлтэгч малаа жил бүр тогтвортой өсгөж, түүний нийт сүрэгт эзлэх хувь бог малд 40, бод малд 35-с доошгүй байх.

3.7. Тухайн жилийн эрсдэлээс шалтгаалж өрхийн хэрэгцээний өвс, тэжээлийг бэлтгэн нөөцөлсөн байх,

3.8.Өөрийн эзэмшлийн өвөлжөөтэй байх бөгөөд, өвөлжөөг сумын жишиг өвөлжөөний стандартаар тохижуулсан байна.

3.9.Тухайн малчин нь бэлчээр нутгийн маргаангүй, хувь хүний харилцаа хандлага зөв байх, ёс суртахуунтай, ойр орчны айл саахалтаараа хамтын хөдөлмөр эрхэлдэг байх.

3.10.Бод малыг уналга эдэлгээнд сурган ашиглаж, өөрийн мал маллах туршлага, арга ухааныг бусдад түгээн дэлгэрүүлэх.

3.11.Жорлон, муу усны нүхээ байгальд ээлтэйгээр шийдвэрлэж, бэлчээр нутаг, буудлын ойр орчны хог хаягдлаа цэвэрлэж ангилах, санаачилгатай ажилласан байх.

3.12.Сайн туршлага, мартагдсан өв соёл малчин ухааныг судлан суралцаж нутагшуулж байх.

3.13.Бүс нутгийн цаг агаар, уур амьсгалд тохирсон ашиг шим сайтай хээлтэгч, хээлтүүлэгчээр сүргийн бүтцийг сайжруулж, цахим мэдээллийн санд 10-с доошгүй хувийг бүртгэлжүүлсэн байх.

3.14.Багийн Иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн малжуулах шаардлагатай өрхийг малжуулсан байна.

3.15.Уур амьсгалын өөрчлөлт, экологийн доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх ажилд санаачилгатай оролцож, ногоон байгууламж байгуулах, бэлчээр уст цэгийг сэргээхэд бодит хувь нэмэр оруулсан байх.

4. Бүрдүүлэх материал

4.1.Малчны товч анкет (энэхүү журмын 01 дүгээр хавсралт).

4.2.Журамд заасан шаардлагыг хангасан тухай багийн Засаг даргын тодорхойлолт.

4.3.Багийн иргэдийн нийтийн хурлаар дэмжигдсэн хурлын тэмдэглэл.

4.4.Мал эмнэлгийн арга хэмжээнд хамрагдсан тухай аж ахуй нэгжийн тодорхойлолт

4.5.Шалгуур үзүүлэлтүүдийн 3.2- 3.8, дахь заалтуудад заасан хавсралтууд бүрэн байх.

5.Шалгаруулалт

5.1.Шаардлага хангасан малчны тодорхойлолтыг дараа оны 01 дүгээр сарын 15-ний өдрийн дотор сумын Засаг даргын тамгын газрын Хөдөө аж ахуйн тасагт ирүүлнэ..

5.2.Тухайн оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн дотор засаг даргын зөвлөлөөр хэлэлцэж шалгаруулна.

6.Шагнал олгох

6.1.Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгнээс өмнө гардуулна.

6.2.Сумын сайн малчинд тууз, энгэрийн тэмдэг, өргөмжлөл дурсгалын зүйл олгоно.

6.3.Сумын сайн малчны шагналыг 300.000 (гурван зуун мянга) төгрөгт багтаан Орон нутгийн нөөц хөрөнгөөс санхүүжүүлнэ.